

АПЕК-ийн ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ СИЭТЛИЙН
УУЛЗАЛТ

Б.Балдоо

Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны нэг шинэ байгууллага- "Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа" /АПЕК/ 5-н жилийн өмнө байгуулагджээ. Бүс нутгийн энэ байгууллагыг бий болгох санаачилгыг Австрали улс гаргаж Ази, Номхон далайн бусад улс дэмжжээ. Санаачилагч орны хувьд Австрали бүс нутгийн улсуудын анхны уулзалт-Гадаад явдалын яамдын сайд нарын бага хурлыг өөрийн орондоо 1989 онд зарлан хуралдуулж, АПЕК-ийг албан ёсоор байгуулжээ. Тус байгууллагад Австрали, АНУ, Гонконг, Канад, Мексик, Өмнөд Солонгос, Папуа Шинэ Гвиней, Тайвань, БНХАУ, Шинэ Зеланди, Чили, Япон болон АСЕАН-ны 6 орон-Индонези, Малайз, Брунеи, Сингапур,Филлиппин, Тайланд зэрэг нийт 17 орон нэгдэн оржээ.

АПЕК нь Америк, Канад, Ази, Номхон далайн уудам нутаг дахь олон талын ашиг сонирхолыг зохицуулах, Өмнөд Умардын ялгааг багасгах, чөлөөт худалдааг хөгжүүлэн түүнийг хэрэгжүүлэх чөлөөт бүс байгуулах гэсэн нийгмийн систем болон эдийн засгийн түвшингийн ялгааг давсан бөмбөрцгийн шинжтэй хамтын ажиллагааг явуулах нэг чухал шинэ хэлбэр болон үүсчээ. АПЕК-т явагддаг ярилцлага маргаан нь эдийн засгийн асуудалд гол анхааралаа төвлөрүүлж улс төр ба аюулгүй байдлын асуудлуудыг ихэнхдээ тойрон гарч, энэ утгаараа үйл ажиллагаа нь улс орнуудын хөгжлийн асуудлыг шийдвэрлэх зорилгод чиглэгддэг.

Энэхүү байгууллага байгуулагдаад удаагүй ч үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөн, бүс нутагт эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, худалдааг чөлөөтэй болгох үйлст чухал үүрэг гүйцэтгэж ирэв.

АПЕК-т элсэн орохыг бүс нутгийн бусад орон хүсэх болсон бөгөөд түүний нэг нь Монгол улс юм. Монгол улсын Засгийн газар тус байгууллагад элсэх хүсэлтийг энэ

оны эхээр албан ёсоор тавьж, элсэх бэлтгэлийг хангах зорилготой Үндэсний хороог байгуулан ажиллуулж байна.

1993 оны 11-р сард АНУ-ын Сиэтл хотод АПЕК-ийн чуулган уулзалт болж түүнд гишүүн улсуудын төр, Засгийн тэргүүн нар оролцов. Энэ чуулга нь Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн амаргүй өөрчлөн байгуулалтыг авч хэлэлцэн түүнд ихээхэн хувь нэмэр оруулсан юм. АПЕК байгуулагдсан цагаас хойш эдийн засгийн хамтын ажиллагааны нэн чухал байгууллага болох төлөвтэйгээр хувьсан хөгжиж эдийн засгийн өргөн хамтын ажиллагаа, худалдааны чөлөөт байдлыг бүс нутагт ихээхэн урагшлуулав. Сиэтлд болсон уулзалтын дүнгийн тухай мэдээнд дурьдсанаас үзвэл: Өнөөдөр АПЕК-ийн гишүүн орнуудын эдийн засаг хамтадаа дэлхийн хүн амын хагас, дэлхийн нийт бүтээгдэхүүний хагас, дэлхийн худалдааны 40 гаруй хувийг төлөөлөх боллоо. 2000 онд энэ үзүүлэлт цаашид өсөх төлөвтэй. АНУ-ын хувьд энэ хамтын ажиллагаа нь их ашигтай гэж үздэг. Жишээ нь, 1993 онд АНУ-ын экспортын таваарын бараг 60%, импортын 67% нь АПЕК-ийн бусад оронд оногдож байна. 1992 онд АПЕК-ийн орнуудын эдийн засгуудтай хийсэн АНУ-ын нийт худалдаа нь Европын холбоотой хийсэн худалдаанаас 3 дахин давсан байна.

1993 оны 11-р сард Сиэтлд болсон АПЕК-ийн дээд хэмжээний уулзалтаар АНУ АПЕК-ийн даргаар ажилласан нэг жилийн хугацаа дуусаж байгаа юм. АПЕК-ийн орнуудын удирдагчид тус байгууллагыг бэхжүүлэх, түүнийг бүс нутгийн бизнесийн хүмүүсийн бодит ажилд улам улам ач холбогдолтой болгох талаар чухал алхам хийж, цаашид Ази, Номхон далайн бүс нутагт эдийн засгийн харилцааг илүү нээлттэй, илүү хамтарсан шинжтэй болгохын төлөө ажиллахаар тохиролцсон гэж Сиэтлийн уулзалтын дүнгийн талаар хийсэн мэдэгдэлдээ АНУ-ын ерөнхийлөгч мэдэгдсэн байна.

Сиэтлийн ойролцоох Хар арал дээр АПЕК-ийн удирдагчидыг ерөнхийлөгч Б.Клинтон хүлээн авч ярилцсан нь энэ байгууллагын үйл ажиллагаанд тохиолдож буй түүхэн уулзалт болсон гэж дэлхийн хэвлэлд цохон тэмдэглэсэн байна. "Энэхүү урьд өмнө болж байгаагүй уулзалт нь бүс нутагт шинэ дуу хоолойг өргөж, түүний янз

бүрийн динамик эдийн засгуудын эрч хүчийг өрнүүлэх шинэ суурийг бий болгох бололцоо төрөн гарсныг харуулав" гэж АНУ-ын төрийн департаменттаас нийтэлсэн баримт бичиг дурьдав.

Уулзалтанд оролцсон орнуудын удирдагчдийн ярилцлага санал солилцолт нь эдийн засгийн асуудлууд улс үндэстний тэргүүлэх зүйлс, нийт бүс нутгийн эдийн засгийн бодит хөгжил цэцэглэлд хүргэх механизм зэрэг үндсэн асуудалд төвлөрч байжээ. Удирдах зүтгэлтэн нар дараагийн жилд хийх ажлынхаа чиглэлээр нилээд санаачилга гаргасан бөгөөд тэдгээр нь нээлттэй байдал хамтын ажиллагааны үзэл санаан дээр үндэслэж, нийт Номхон далайн сав газрын эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах болно. АПЕК-ийн хүчин чармайлт тус чуулганаар дэвшүүлсэн дараах санаачилгуудыг хэрэгжүүлэхэд хэрэглэнэ. Үүнд:

-АПЕК-ийн Сангийн Сайд нарын хурал зарлан хийж эдийн засгийн өргөн асуудал хэлэлцэх.

-Номхон далайн Бизнесийн чуулга бий болгож, түүгээр бүс нутгийн худалдаа ба хөрөнгө оруулалтын хөнгөвчилөхөд АПЕК хүч чармайлтаа чиглүүлвэл зохих асуудлуудыг бизнесийн ахлах зиндааны төлөөлөгчид хэлэлцэн нэг мөр болгож байх.

-Бүс нутгийн боловсролын түвшинг дээд шатнаа гарган хөгжүүлэхийн тулд АПЕК-ийн боловсролын хөтөлбөр бий болгох.

-Хүний бололцоо нөөцийг хөгжүүлэхэд хамтран ажиллах явдлыг хөгжүүлэх зорилгоор АПЕК-ийн Бизнесийн сайн дурынхны хөтөлбөр бий болгох.

-Жижиг ба дунд үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны нөхцөлийг сайжруулах арга замыг хэлэлцэхийн тулд АПЕК-ийн Сайд нарын уулзалтыг зарлан хуралдуулах.

-Эрчим хүчийг хамгаалан хадгалах, хүрээлэн буй орчныг сайжруулах, эдийн засгийн өсөлтийг тогтворжуулахын тулд АПЕК-ийн яриа хэлцэлийн бодлого ба үйл ажиллагааны төлөвлөгөөг хөгжүүлэх.

-АПЕК-ийн гишүүн орны дотор технологи ба технологийн удирдлагын ур чадварыг харилцан солилцоход дөхөм үзүүлэх төвийг бий болгох зэрэг санаачилга болно.

Сангийн Сайд нарын үүлзалт

АПЕК-ийн удирдагчдын дэвшүүлсэн нэг санаачилга бол АНУ-ын Сангийн сайд зохион байгуулан 1994 оны 3-р сард Гонолулуд хийх АПЕК-ийн Сангийн 17 сайдын анхны уулзалт юм.

-Энэ уулзалтаар бүс нутгийн макро эдийн засгийн хөгжил, амжилттай өсөлтийг хангах үндсэн стратегийн асуудлыг хэлэлцэх, тэгэхдээ тогтвортой өсөлтийг бий болгоход хувийн хөрөнгө оруулалт, түүний дотор гадаадын хөрөнгө оруулалтын үүргийн ач холбогдлыг онцлон авч үзэх.

-Бүс нутгийн дэд бүтцийг өргөтгөх буюу шинэчилэх /модернизацилах/ явдал шаардлагатай байгааг харгалзан Сайд нар эдгээр хоёр янзын хөрөнгө оруулалтыг хэрхэн санхүүжүүлэх, хувийн хөрөнгө оруулалтын талаар хийгдэж буй зоримог алхмыг хэрхэн үргэлжлүүлэх асуудлыг авч хэлэлцэх.

-Дотоодын ба олон улсын капиталын зах зээлийн үр ашиг болон эдгээр зах зээлд нүүрлэж байгаа бэрхшээлийн асуудлыг онцгойлон авч үзэх болно.

АПЕК-ийн байгаль орчны Сайд нарын үүлзалт

Хүрээлэн буй орчны талаар сэтгэл түгшиж буй АПЕК-ийн сайд нар байгаль орчны асуудалд зориулан 1994 оны 3-р сард хийх АПЕК-ийн өндөр төвшний хурал дээр уулзах юм. Канадын ерөнхий сайдын орлогч, байгаль орчны сайд энэ уулзалтыг Канадын Ванкувер хотод зохионо.

АПЕК-ийн сайд нарын хурал болох үеэр Ванкуверт 12 мянган хүн оролцох төлөвтэй "Глобе-94" хэмээх олон улсын худалдааны үзэсгэлэн нээж бага хурал зохиох юм. Глобе бага хурал бизнес ба хүрээлэн буй орчны тухай асуудал хэлэлцэнэ. АПЕК-ийн байгаль орчны сайд нарын уулзалтаар дараах асуудлууд хэлэлцэнэ. Үүнд:

-Хүрээлэн буй орчин ба тогтвортой хөгжлийн талаар АПЕК-ийн гишүүн орнуудын үүрэг хариуцлагыг онцлон дурьдахаар төлөвлөж буй Мэдээлэл:

-АПЕК-ийн эдийн засгийн ба байгаль орчны интеграцийг

Сангийн Сайд нарын уулзалт

АПЕК-ийн удирдагчдын дэвшүүлсэн нэг санаачилга бол АПЕК-ийн Сангийн сайд зохион байгуулан 1994 оны 3-р сард Тондлууд хийх АПЕК-ийн Сангийн 17 сайдын анхны уулзалт юм.

-Энэ уулзалтаар бүс нутгийн макро эдийн засгийн хөгжил, амжилттай өсөлтийг хангах үндсэн стратегийн асуудлыг хэлэлцэх, тэгэхдээ тогтвортой өсөлтийг бий болгоход хувийн хөрөнгө оруулалт, түүний дотор гадаадын хөрөнгө оруулалтын үүргийн ач холбогдлыг онцлон авч үзэх.

-Бүс нутгийн дэд бүтцийг өргөтгөх буюу шинэчилэх/модернизацилгах/ явдал шаардлагатай байгааг харгалзан Сайд нар эдгээр хоёр янзын хөрөнгө оруулалтыг хэрхэн санхүүжүүлэх, хувийн хөрөнгө оруулалтын талаар хийгдэж буй зоримог алхмыг хэрхэн үргэлжлүүлэх асуудлыг авч хэлэлцэх.

-Дотоодын ба олон улсын капиталын зах зээлийн үр ашгийг болон эдгээр зах зээлд нүүрлэж байгаа бэрхшээлийн асуудлыг онцгойлон авч үзэх болно.

АПЕК-ийн байгаль орчны Сайд нарын уулзалт

Хүрээлэн буй орчны талаар сэтгэл түгшиж буй АПЕК-ийн сайд нар байгаль орчны асуудалд зориулан 1994 оны 3-р сард хийх АПЕК-ийн өндөр төвшний хурал дээр уулзах юм. Канадын ерөнхий сайдын орлогч, байгаль орчны сайд энэ уулзалтыг Канадын Ванкувер хотод зохионо.

АПЕК-ийн сайд нарын хурал болох үеэр Ванкуверт 12 мянган хүн оролцох төлөвтэй "Глобе-94" хэмээх олон улсын худалдааны үзэсгэлэн нээж бага хурал зохиох юм. Глобе бага хурал бизнес ба хүрээлэн буй орчны тухай асуудал хэлэлцэнэ. АПЕК-ийн байгаль орчны сайд нарын уулзалтаар дараах асуудлууд хэлэлцэнэ. Үүнд:

-Хүрээлэн буй орчин ба тогтвортой хөгжлийн талаар АПЕК-ийн гишүүн орнуудын үүрэг хариуцлагыг онцлон дурьдахаар төлөвлөж буй Мэдээлэл:

-АПЕК-ийн эдийн засгийн ба байгаль орчны интеграцийг

хэрэгжүүлэх санал бодолд үндэс болгох зарчмууд.

-Байгаль орчны технологи, тухайлбал бохирдлоос хамгаалах асуудал, цэвэр технологи.

-Улс төрийн бодлогын арга хэрэгслүүд, тухайлбал эдийн засгийн арга хэрэгсэл, байгаль орчны стандарт.

-Хотуудын тогтворжилт.

-Байгаль орчны боловсрол ба мэдээлэл зэрэг асуудал болно.

Жакартын ахлах зиндааны ажилтан нарын үүлзалтын /СОМ/ дүн

Индонези улс АПЕК-ийн ахлах зиндааны ажилтан нарын дөрвөн удаагийн уулзалтын анхныхийг 1994 оны 2-р сард Жакартад зохиожээ. Дараагийн уулзалтыг 5,9-р сард хийж, эцсийнхийг 1994 оны 11-р сард АПЕК-ийн сайд нарын уулзалтын өмнөхөн хийх юм.

Ахлах зиндааны ажилтан нар АПЕК-аас энэ жилийн туршид явуулах ажилд ажиглалт хийж, Сайд нарын жил тутмын уулзалтад бэлтгэх үүрэгтэй. СОМ-ын ажилд Индонезийг төлөөлж Элчин сайдын зиндааны хүн АНУ-ыг төлөөлж Төрийн нарийн бичгийн даргын туслахын орлогч зиндааны хүн оролцсон байна.

Жакартын СОМ нь АПЕК-ийг зохион байгуулан даргалах ажил аажмаар АНУ-аас Индонезид шилжих, Сиэтлийн уулзалтаар тохирсон зүйлс цааш үргэлжлэн хэрэгжиж буйг харууллаа. Мөн түүнчлэн Хар аралд болсон удирдагчдын уулзалт АПЕК-ийн хөгжилд шинэ үеийг авчирсныг энэ уулзалт харууллаа. АПЕК нь урьд ерийн нэгэн байгууллагын шинжтэй ажиллаж байснаа одоо АПЕК-ийн худалдаа, хөрөнгө оруулалтын хороо, эдийн засгийн хөгжлийн хандлага ба асуудлыг судлах тусгай групп болон ажил төрлийн 10 группийг өөртөө багтаасан улам өсч буй иж бүрэн бөгөөд бие даасан хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг хүчин чармайлтаа дайчилан ажиллах боллоо.

Жакартын СОМ-ын гол ололт бол худалдаа ба хөрөнгө оруулалтын шинэ хороо /СТИ/ болон түүний 10 зүрх /гааль, тариф, хөрөнгө оруулалт, захиргааны асуудал гэх зэргийг багтаасан/ ажлын хөтөлбөрийг бий болгон

ажилдуулж эхэлсэн явдал юм. Шинэ Хорооны хуралдаанаар АПЕК-ийн гишүүн орчуудын хөрөнгө оруулалтын хөрөнгөтүүдийг авч үзэх тухай АНУ-ын саналыг авч АПЕК-ийн хуралдааны сайд нарын уулзалтыг ирэх намар АНУ-д эхлээд тогтов.

АПЕК-ийн дээд зиндааны ажилтны уулзалт энэ жилийн АПЕК-ийн ажлыг хүний бололцоо нөөцийн хөгжлийн асуудал, жижиг ба дунд хэмжээний үйлдвэрийн газруудын асуудал дээр төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзээд жижиг, дунд хэмжээний үйлдвэрийн газруудыг хөгжүүлэх АПЕК-ийн өргөжилтэн нарын уулзалтыг хуралдуулах болов.

Жакартын СОМ-ын нөгөө нэг ололттой зүйл бол АПЕК-ийн Төсөв ба Захиргааны шинэ хороог байгуулсан явдал юм. Энэ хороо АПЕК-ийн санхүүгийн байдлын талаархи хэлэлцэх тэргийн төлөвлөгөөг авч үзэн, захиргааны ба ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх талаар зөвлөмж гаргах болно. Гишүүн орнуудын саналаар энэ жил тус хорооны даргаар АНУ ажиллах боллоо.

Сиэтлд болсон АПЕК-ийн орнуудын Сайд нарын Зиндааны ээлжит чуулганд гишүүн орнуудын төр, засгийн тэргүүн нар оролцож, шинэ чухал санаачлагууд гарган, тэдгээрийн практик дээр хэрэгжүүлж эхэлсэн явдал "Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа" байгууллагын үйл ажиллагааг өргөтгөн гүнзгийрүүлэх, цаашид идэвхжүүлэхэд түүхэн үүрэг гүйцэтгэх болно.